



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/77

Маңдалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/226 дугаар тушаал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж буй Дундговь аймгийн Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн автомашин хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Ц.Энхсайхан (Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Г.Болдмаа (Эрүүл мэндийн газрын удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд:

Р.Мөнхбаясгалан (Эрүүл мэндийн газрын удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Цэрэннадмид (Эрүүл мэндийн газрын удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Эрдэнэчулуун (Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн их эмч)

2. Автомашиныг батлагдсан техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга (Ц.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНТӨГС